

## КИМ ИР СЕН БА БНМАУ

*К.Дэмбэрэл\**

БНМАУ нь БНАСАУ-тай 1948 оны 10-р сарын 15-нд дипломат харилцаа тогтоосон үеэс албан ёсны харилцаа идэвхтэй хөгжиж эхэлсэн. 1950 онд БНМАУ-аас БНАСАУ-д элчин сайдын яамаа нээн ажиллуулж эхэлсэн бол 1951 онд БНАСАУ-аас БНМАУ-д ЭСЯ-аа нээжээ.

Монгол Улсын гадаад харилцааны яамны архивт хоёр орны харилцааны талаарх баримт материалууд 1922-1990 оныг хамран 320 хадгаламжийн нэгжтэйгээр тус архивын III фондод хадгалагдаж байгаа болно. Тухайн материалаас хамааран нууцын зэрэглэл нь өөр өөр байгаа. МАХН-ын Төв архивын IY фондод БНАСАУ-тай холбогдолтой материалууд нэлээд олон нэгжтэйгээр хадгалагдаж байна. Манай архивын материалуудад Солонгосыг 1950-60-аад онуудад бол АБНСАУ, 1980-аад оны материалуудад БНАСАУ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Ер нь архиваас энэ сэдэвтэй холбогдолтой материалуудыг зөвхөн ил гаргах төдий бус хоёр орны хоорондын харилцааны асуудал, нэн ялангуяа БНАСАУ-ын лидер агсан Ким Ир Сений үйл ажиллагааг судлан судалгааны эргэлтэд оруулах нь судлаачдын үүрэг гэлтэй.

Манай архивуудад буй 1950-1960-аад онуудын үеийн хоёр орны харилцааны талаарх материалуудыг нарийвчлан үзэх нь Солонгосын хойгийн дайн, түүний дараах үеийн үйл явдлуудыг тодотгож өгөх боломжийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Солонгосын хойгийн дайн нь Ази дахь “хүйтэн дайны” эхлэл төдийгүй хоёр системийн зөрчлийг бодитой болгож өгсөн хэмээн үзэх үндэстэй. Системийн зөрчилд зөвхөн нэг талын эрх ашигт үнэнч байсан БНМАУ-ын зүгээс БНАСАУ-ыг холбоотноо хэмээн үзэж ядмаг эдийн засгаа үл хайхран бололцоотой бүхнээрээ туслаж байсныг Монголын архивын баримтууд нотолж байгаа.

Хоёр орны төрийн тэргүүн нар дээд хэмжээний айлчлалыг харилцан 4 удаа хийсэн байна. БНАСАУ-ын төрийн тэргүүн их жолоодогч Ким Ир Сен БНМАУ-д Ю.Цэдэнбалын урилгаар 1956 онд, 1988 онд Ж.Батмөнхийн урилгаар төрийн айлчлалыг тус тус хийсэн байна. 1952 онд Москва орох замдаа БНМАУ-аар дайран өнгөрч байжээ. Ж.Батмөнх 1986 онд БНАСАУ-д албан ёсны айлчлал хийсэн юм.

---

\*К.Дэмбэрэл – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Монголын архивт буй Ким Ир Сентэй холбогдолтой материалууд нь зөвхөн түүнийг хувь хүний хувьд мөн нэлээд өвөрмөц замаар замнасан улс орны тэргүүний хувьд судлах төдийгүй БНАСАУ-ын талаарх судалгааг гүнзгийрүүлэхэд тус дөхөм болно хэмээн судлаачийн хувьд үздэг юм.

Монгол Улсын гадаад хэргийн яамны архивын 100, 309 тоот дансанд Ким Ир Сений албан ёсны хоёр удаагийн айлчлалын талаарх 329 хуудас материал хадгалагдаж байна.

Энэ удаад Гадаад хэргийн яамны архивын III фондын 309 тоот данснаас Ким Ир Сений 1988 онд хийсэн айлчлалын үеийн ганцаарчилсан уулзалт ярианы тэмдэглэл, МАХН-ын Төв архивын IV фондоос Ким Ир Сентэй холбогдох цөөн материалуудад тулгуурлан анализ хийхийг оролдлоо. СХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНАСАУ-ын тэргүүн Ким Ир Сений МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх болон МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, НТХ-ны нарийн бичгийн дарга Д.Моломжамц нартай хийсэн ганцаарчилсан ярианы тэмдэглэлд голлон анхаарав.

Манай хоёр орны харилцаанд онцлог зүйлийн нэг гэвэл 1956 оны 7-р сард СХН-ын ТХ-ны дарга, БНАСАУ-ын Сайд нарын танхимын дарга Ким Ир Сен БНМАУ-д айлчилсан бол 3 сарын дараа 1956 оны 10 сарын сүүлчээр БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал БНАСАУ-д албан ёсны айлчлал хийсэн ба энэ харилцаа 30 жилийн дараа 1986 онд МАХН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх БНАСАУ-д төрийн айлчлал хийсний дараа 1988 онд Ким Ир Сен БНМАУ-д хоёр дахиа албан ёсоор айлчилжээ. Хоёр орны бусад удирдлагуудын харилцан айлчлал харьцангуй ойр интервалтай байсан. Ким Ир Сен анх 1956 онд Монголд айлчилснаас хойш 32 жилийн дараа БНМАУ-д хүрэлцэн ирсэн байна.

БНМАУ-аас БНАСАУ-тай тогтоосон харилцаа нь социалист системийн орнуудын улс хоорондын харилцааны салшгүй нэг хэсэг байсан. Энэ утгаараа хоёр орны харилцааг социалист системийн орнуудын харилцааны судалгааны арга зүй, эх сурвалжийн хувьд нэгэн адил авч үзэх ёстой. Хоёр орны харилцаа тийм ч ойр дөт нягт байж чадаагүй гэж дүгнэж болно. Ер нь харилцаа нь Азийн социалист бөгөөд ойр дөт орших, түүхийн хувьд ч гарал үүсэл ойр хэмээн үздэг орнуудын хувьд илүү ойр дотно байх боломж өндөр байсан хэдий ч тийм байж чадаагүй. Энэ нь зөвхөн хоёр улсын тэргүүнүүд дипломат харилцаатай

40 гаруй жилийн туршид нийт 4 удаагийн дээд хэмжээний айлчлал хийснээс харж болно.

Ким Ир Сен 1988 оны айлчлалын үеэр МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ж.Батмөнхтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр улс орныг хөгжүүлэх талаар түүний баримгалдаг зарим санаа бодлоо илэрхийлсэн байсныг сийрүүлбэл зөвхөн биеэ дааж хөгжих ёстой гэсэн үзэл түүнд бат бөх шингэсэн байна.

Ерөнхийлөгч Ким Ир Сен Монгол орны хүн амыг өсгөх нь түүний хөгжилд жинхэнэ хувь нэмэр болох юм гэсэн үүднээс дараах санааг илэрхийлсэн байна. Үүнд: "...Танай орон 20 сая хүнтэй байсан ч болох байна. 50 сая хүнтэй ч байж болно. Газрын доорх баялаг ихтэй орон байна. Аж үйлдвэрийг хөгжүүлбэл хичнээн ч олон хүнийг тэжээж болох юм. Аж үйлдвэрийг, ялангуяа машины аж үйлдвэрийг хөгжүүлэх хэрэгтэй гэж нөхөр Д.Моломжамц (МАХН-ын ТХ-ны УТТ-ийн гишүүн, НТХ-ны нарийн бичгийн дарга) өчигдөр ярьж байсан"<sup>1</sup> хэмээн Ж.Батмөнхөд онцгойлон хэлж байжээ.

Тэрээр Монгол орны төмрийн хүдэр болон бусад ашигт малтмалын нөөцийг сонирхохын хамт улс орноо үйлдвэржүүлэх өөрийн бодлоо "...юуны түрүүнд машины аж үйлдвэрийг хөгжүүлэх хэрэгтэй. Яагаад гэвэл машины үйлдвэрийг хүнд аж үйлдвэрийн зүрх гэж ярьдаг юм. Иймээс бүр дайны үед манай оронд машины аж үйлдвэрийн суурийг тавьж, суурь машины үйлдвэр барьж эхэлсэн. Манай оронд машин үйлдвэрлэх хүч чадал ихэд нэмэгдсэн. Машины аж үйлдвэр төвөгтэй, нарийн мэргэжил, цаг хугацаа шаарддаг. Зөвлөлтийн нөхөд энэ салбарт хамтран ажиллах санал бидэнд тавьж байна. Олон зүйлээр хамтран ажиллахаар тохирсон. Машины аж үйлдвэрийг эхлэн хөгжүүлэхэд төмөр бага хэрэглэх бөгөөд түүнийг гадаадаас авч болно. Танай орон төмрийн хүдэр, коксждог нүүрсээр баян байна. Иймээс төмрийг үйлдвэрлэж, улмаар гадаадад гаргаж болох байна. Ган төмрийг хайлуулдаг болсон үед машины үйлдвэрийг хөгжүүлж болно. Ер нь өсөн нэмэгдэж буй хүн амыг дан ганц мал аж ахуйгаар тэжээж чадахгүй юм. Иймээс газрын доорх баялгийг нээж ашиглахыг бодох хэрэгтэй. Танайд төмрийн хүдэр, коксждог нүүрс их байна. Гэтэл манайд коксждог нүүрс байхгүй. Одоо коксждог нүүрс хэрэглэхгүйгээр төмрийг хайлуулах аргыг нэвтрүүлж байна. Одоо дэлхий дээр хэт өндөр долгионыг ашиглан ган хайлуулж байна. Бид энэ талаар нэлээд судалгаа хийж байна."<sup>2</sup> хэмээн илэрхийлсэн.

Монголын талын хийж буй болон хийхээр төлөвлөсөн ажлуудыг дэмжин Ким Ир Сен цааш нь ярихдаа: “Таны ярьж байгаа зүйтэй байна. Төмрийн үйлдвэрийн тухайд бол цахилгаан зуухаар төмөр хайлуулах асуудлыг амархан шийдвэрлэж болно. Энэ талаар манай оронд хийж байгаа зүйл нэлээд бий. Манайд 800 мянган тонн ган үйлдвэрлэх цахилгаан зуух байна. 900 мянгаас нэг сая тонн ган үйлдвэрлэдэг зуух ч байна. Мөн 100-200 мянган тонн хаягдал төмөр хайлуулах үйлдвэр ч байна. Үүнээс гадна Пхеньян болон бусад мужид 50-60 мянган тонн ган үйлдвэрлэх хүчин чадалтай хаягдал төмрийг хайлуулдаг үйлдвэр байна. Одоо зарим үйлдвэрийн хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Иймээс ган төмөрлөгийн үйлдвэрийн салбарт бид мэргэжилтэн өгч болно. Төсөл зургийг хамтран боловсруулж болох юм. Мөн төмөрлөгийн үйлдвэр хөгжүүлэх талаар ч бид туслах боломжтой. Эхлээд хаягдал төмөр ашиглах бага хүчин чадлын цахилгаан зуух байгуулах нь зүйтэй юм. Түүхий эд дутагдалтай учраас манай төмөрлөгийн үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна. ЗХУ төмөр нийлүүлж ган цувимал болгуулах санал тавьсан. Энэ нь бололцоотой юм. Танай мэргэжилтнүүд манайд очиж төмөрлөгийн үйлдвэр үзэж болно. Бид бүгдийг үзүүлнэ. Бид та нөхдөд туслая. Техникийн талын туршлага хуваалцахад ямар бэрхшээл байх вэ? Манайх эдийн засгийн тооцоо ч гаргаж болно. Манайд төмөрлөгийн үйлдвэрийн талаар туршлагатай хүмүүс бий. Японы колоничлолын үед төмөрлөгийн үйлдвэрт ажиллаж байсан 400 гаруй хүнийг одоо зөвлөхөөр ашиглаж байна”<sup>3</sup> гэжээ.

Химийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд туслах боломжийн тухай Монголын талын саналыг тун нааштай хүлээн авсан төдийгүй Ким Ир Сен энэ чиглэл Солонгос хэрхэн ажиллаж буйг зарим баримтаар хэлж байсан. Тэрээр хэлэхдээ: “Химийн аж үйлдвэрийн тухайд гэвэл танайд шохойн чулуу, нүүрс их байгаа тул хөгжүүлэх боломжтой юм. Танайд коксжлог нүүрсээр карбинатыг гаргаж болохоор байна. Карбинатаас химийн бордоо, хуванцар, мяндас гэх мэтийг үйлдвэрлэж байна. Энэ аргыг Японд суралцаж байсан солонгос хүн нээсэн гэдэг. Тэр эрдэмтэн Японы дээд сургуульд суралцаж байхдаа докторын диссертаци бичсэн бөгөөд тэр нь одоо Парис, Лондон, Берлины номын санд байна. Японыг бууж өгсний дараа тэр эрдэмтэн Солонгост буцаж ирсэн. Тэр үеийн Өмнөд Солонгосын ерөнхийлөгч агсан Ли Сен Ман тэр эрдэмтнийг ашиглаж чадаагүй юм. Одоо надтай хамт яваа дэд ерөнхийлөгч Ли Жон Ок Өмнөд Солонгосоос тэр эрдэмтнийг дагуулж ирсэн юм. Яг тэр

үед бид Америкийн империализмын эсрэг дайн хийж байсан учраас эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулах боломжгүй байв. Иймээс Хятадын хилийн ойролцоо нэг хотод жижиг эрдэм шинжилгээний газар байгуулж тэр эрдэмтнийг ажиллуулах болсон юм. Дайны дараа 20000 тонны хүчин чадалтай виналионы анхны үйлдвэр байгуулсан. Түүнийг өргөтгөж 50000 тонны виналион үйлдвэрлэх хүчин чадалтай болгосон. Одоо 100 мянган тонн виналион үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр барьж байна. Бид энэ чиглэлээр монгол нөхдөд туслалцаа үзүүлэхэд бэлэн байна. Надтай хамт яваа Гадаадтай эдийн засгаар харилцах хорооны дарга бол Елена Чаушескутай хамт сурч байсан химийн мэргэжлийн хүн. Би түүнийг төлөвлөгөө эдийн засгийн чиглэлээр ажиллуулж байгаа. Танай нөхөд биднийг энд байх хугацаанд түүнтэй уулзаж санал солилцож болох юм. Би өчигдөр түүнээс виналионы үйлдвэр хөгжүүлэх боломжтой юу хэмээн асуухад боломжтой хэмээн тэр хариулсан. Виналион нь хөвөнгөөс бөх эдлэгээтэй, хөлс уухдаа ч мулгүй. Бид та нөхдөд тусалж болно. Та энэ асуудлыг сонирхож байгаа учраас би өөрийн нөхдөд чиглэл өгнө”<sup>4</sup>.

Мөн Солонгос нь барилгын салбарт ч туслах боломжтой хэмээн Ким Ир Сен амлаж байлаа. Тухайлбал: “Зөвлөлтийн нөхөд Находка, Владивосток, Хабаровскт 800-1000 хүртэл хүн хүлээн авах зочид буудал, театр, циркийн барилга бариулах хүсэлт тавьсан. Энэ талаар Танд хандаж хэлэх зүйл байна уу? Байвал хэлээрэй. Хэрвээ Зөвлөлтийн тал цемент, машин, тоног төхөөрөмж гаргавал энэ оны эцсээс ч уг барилга, байгууламжийн ажлыг эхэлж болох юм”<sup>5</sup>.

Монгол, Солонгосын талууд эдийн засгийн салбарт хамтран ажиллах зарим тооцоо, судалгааг хоёр талаасаа хийж байсныг сайшааж хэлэхдээ: “Манай нөхөд Монголд явсан дүнгээ надад танилцуулсан. Тэр үндсэн дээр бид Монголоос коксждог нүүрс Хятадын төмөр замаар дамжуулан тээвэрлэх бололцоо байгаа эсэх талаар Хятад нөхдийн саналыг асуусан. Тэд хариу өгөөгүй байна. Зөвлөлтийн нутгаар дамжуулж Находка хүргэж тэндээс усан онгоцоор авах боломж байгаа юм. Гэвч энэ нь бас бэрхшээлтэй. Ямар ч нөхцөлд Зөвлөлт, Хятад алинаар нь дамжуулсан ч урьдчилан тохиролцох шаардлагатай юм”<sup>6</sup>.

Ж.Батмөнх- “Энэ ордыг хамтран эзэмшихэд ЗХУ заавал оролцох ёстой юм”. Ким Ир Сен- “Тийм тийм. Ажиллах хүч, зарим талаар бид хандив оруулах боломжтой. Ямар ч аргаар хамтран эзэмшсэн, энэ асуудлыг дээд хэмжээнд, тухайлбал нөхөр Горбачевыг оролцуулахгүйгээр доогуур яриад бүтэхгүй юм”<sup>7</sup>.

Ж.Батмөнх – “450 км-ээс доошгүй урт төмөр зам тавих хэрэгтэй. Мөн энд зэсний баялаг орд (Оюу толгойн орд-К.Д) байгаа юм. Түүнийг хамтран ашиглана гэж үзвэл төмөр зам 500 орчим км тавигдах хэрэгтэй болж байна”<sup>8</sup>.

Ким Ир Сен – “Энэ ч гайгүй хэрэг, 50 км-ын наана цаанын ялгаа гайгүй. Манайд давс байхгүй. Бид давсны талбай байгуулж тарьж байгаа. Гэтэл химийн үйлдвэр хөгжүүлэхэд одоогийн үйлдвэрлэж байгаа давс хүрэлцэхгүй байна. Танайхыг давсны баялагтай гэж сонссон”<sup>9</sup>.

Бүр ярилцлагынхаа эхэнд Ким Ир Сен бүс нутгийн хүрээнд, тухайлбал Зүүн хойд Азид хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэхийн чухалыг онцлон ярьж байсан. Тэрээр хэлэхдээ: “Манай Ази тив, ялангуяа Зүүн хойд Азид оршин тогтнож байгаа социалист орнуудын дотор том орнуудыг эс тооцвол зөвхөн манай хоёр орон л байна. ЗХУ бол том орон, Хятад ч мөн том орон. Вьетнам, Лаос, Кампучи нь Зүүн өмнөд Азийн орнууд юм. Иймээс манай хоёр орон онцгой дотно харилцаатай байх хэрэгтэй юм”<sup>10</sup> тэмдэглэсэн байдаг. Энэ нь бүс нутагт тодорхой хэмжээний найдвартай түншлэл эрэлхийлж байсны илрэл гэж үзэж болох талтай.

Ким Ир Сенийг үдэн гаргаж өгсөн МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, НТХ-ны нарийн бичгийн дарга Д.Моломжамцтай ярилцсан ярианы тэмдэглэлд дараах зүйлүүд тусгагдсан.

Ким Ир Сен –” Би 1984 онд Европын социалист орнуудаар айлчлах үедээ БНМАУ-д ирэх гэж бодож байсан, гэвч улс орны дотоод байдалтай холбогдон ирж чадаагүй билээ”. Энэ нь Ю.Цэдэнбалыг ажлаас нь чөлөөлж байх үетэй давхцсан байна.

1984 онд Зүүн Европт Ким Ир Сений хийсэн албан ёсны айлчлалын материалуудыг мөн Монголд хийсэн 2 удаагийн айлчлалын материалуудыг “Хүйтэн дайн” төслийн хүрээнд нэгтгэн Ким Ир Сений улс төрийн дүр зургийг гаргах бүрэн боломжтой юм.

Эдгээрээс харахад Ким Ир Сений “нуруу өвддөг учир эмч нар онгоцоор явахыг зөвшөөрөхгүй байгаа юм. Ер нь галт тэргээр ч хол газар явах нь төвөгтэй болсон” хэмээн өөрөөр (аюулгүй байдлын үүднээс гэдэг-К.Д) хуучилсан баримт бий.

Монголын аль ч түвшний хүмүүстэй уулзахдаа Ким Ир Сений дурсан ярих дуртай зүйлийн нэг бол “Эх орноо чөлөөлөх дайны үед болон дайны дараах сэргээн босголтын үед ч Монголын ард түмэн манай ард түмэнд эд материалын болон сэтгэл санааны тусламж, дэмжлэг үзүүлж байсныг бид мартахгүй” гэдэг байлаа.

Ким Ир Сен –” БНМАУ манай улс байгуулагдахад ЗХУ-ын дараагаар хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоон элчин сайдаа томилсон хоёр дахь улс юм. БНМАУ-ын анхны элчин сайд Ж.Самбуу дайны хүнд үед давшилтад ороход ч, ухрахад ч бидэнтэй хамт үүргэвчээ үүрч хамтран тэмцэж байсан дайчин нөхөр юм. Би нөхөр Ж.Самбуутай ойр дотно харилцаатай байсан, тэрээр их сайн хүн байсан. Түүхийн өргөн мэдлэгтэй хүн байсан. Би нөхөр Ж.Самбуугаас их зүйлийг сурсан”<sup>11</sup>. Солонгосын хойгийн дайны үед Хойд Солонгост туслах хөдөлгөөн Монгол даяар өрнөж, МАХН-ын ТХ-ны УТТ-ийн товчооны тогтоолууд шил шилээ даран гарч байсан ба эдгээр тогтоолууд нь одоо МАХН-ын төв архивын 4-р фондод голлон хадгалагдаж байдаг. Сонирхуулахад Солонгост туслах, дэмжлэг үзүүлэх Улсын төв комиссыг байгуулан ажиллуулж байсан ба уг комисст орж ажиллаж байсан Н.Дангаасүрэн гуай одоо ШУА-ийн ОУСХ-д ажиллаж байгаа юм. 1950-1952 онуудад комиссын ажил нэлээд ачаалалтай байсан нь архивын баримтуудаас харагдаж байна. Чухам энэ үеэс Солонгосын тэргүүний ажилчид /50 ажилчид/, өнчин хүүхдүүдийг /тэдний тоо 200 орчим байсан/ Монголд хүлээн авч амруулах, хүмүүжүүлэх ажил эхэлсэн ба энэ нь Солонгост явсан Монголын төлөөлөгчдийн саналыг үндэслэсэн байсан. Мөн Солонгост илгээсэн тусламж, эд материалын зүйлүүдийг мөнгөн хэлбэрээр илэрхийлэн гаргасан тоо баримтууд ч архивт хадгалагдан үлдсэн.

АБНСАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Ким Ир Сенээс БНМАУ-ын ерөнхий сайд нөхөр Ю.Цэдэнбалд 1952 оны 11 сарын 03 –нд ирүүлсэн талархалын захиа нь одоо Намын Төв Архивын 4-р фондод хадгалагдаж байгаа бөгөөд түүнд “...бид фронт дээр ч, ар талд ч ах дүү орнуудын тусламж дэмжлэгтэйгээр сүүлийн жилүүдэд ихээхэн амжилтыг байнга олсоор байна. Та бүгдийн онцгой талархалын хариу болгон энэ жилийн ургацын дээжээс бэлэг /нийт 14 тонн орчим цагаан будаа, алим/ болгон явуулав”<sup>12</sup> гэжээ. Энэ бэлгийн жагсаалт нь архив байгаа ба сонирхолтой нь бэлгэн дотор нь “олзны” зэвсэг б ширхэг ирсэн нь фронтын амжилтын баталгаа гэлтэй.

1952 оны 12-р Солонгост явсан Монголын засгийн газрын төлөөлөгчид МАХН-ын УТТ-ны тогтоолоор БНМАУ-ын төр, засгийн өндөр дээд шагналыг Ким Ир Сен болон Хөдөлмөрийн нам, Ардчилсан Солонгос Ард Улсын удирдагчид, ар тал, фронтынхонд гардуулсан ба чухам ямар үндэслэлээр шагнах тухай тодорхойлолтууд нь Намын төв архивт бий”<sup>13</sup>.

1953 оны 7-р сарын 31-ний өдөр АБНСАУ-ын СнЗ-ийн дарга Ким Ир Сен дайн дууссантай холбогдуулан гадаадын дипломатууд, төлөөлөгчдийг хүлээн авсан хүлээн авалтад оролцсон БНМАУ-ын Элчин сайдын тэмдэглэл Гадаад харилцааны яамны архивын 3-р фондод хадгалагдаж<sup>14</sup> байгаа ба арга хэмжээнд нийт 40-45 хүн оролцсон ажээ.

Ким Ир Сений 1956 оны 7-р сард Монгол хийсэн анхны айлчлалын талаарх материал ГХЯ-ны архивын 3-р фондын 100-р хэрэгт хадгалагдаж байдаг. Мөн айлчлалтай холбоотой 15 ш фото зураг ч бий. Энэ айлчлалын маршрут нь Москва-Иркутск-Улаанбаатар-Сайншанд-Мүгдэн-Пхеньян гэсэн чиглэлд онгоцоор үйлдсэн бололтой.

Ким Ир Сен нь өөрийгөө тодорхойлсон зарим ярианд “би залуудаа нэлээд, яаруу, шуурхай хүн байсан, одоо ч нас ахиад тийм зүйлгүй болжээ” хэмээн өгүүлсэн бий.

Тэрээр манайд айлчлах үедээ Солонгос, Монгол хоёр улс эртний уламжлалт сайхан харилцаатай, ураг төрлийн холбоотой байсан хэмээн тодорхой жишээ татан ярьж байсан.

Ким Ир Сен – Галт тэргэнд явах зуураа Монголын талаас үдэн гаргагчидтай ярилцах зуураа дараах санааг нэлээд идэвхтэй хэлж байсан. “Биеэ даасан үндэсний эдийн засгийг хөгжүүлэхгүйгээр эцсийн эцэст байгаа зүйлээ гадагш гаргачихаад хоосон нүх л үлдэхэд хүрнэ. Иймд зоригтой эхлэх хэрэгтэй. Жишээлбэл: Нэг машиныг гадаадын зах зээлээс 30 мянган рубль буюу доллараар авч байна. Дараагийн шатанд тэд дээр нь кран зоочихоод 45 мянган рубль, доллараар өгч байна. Би дайны дараа сэргээн босголтын үед сайд нарын танхимын даргаар ажиллаж байхдаа холбогдох мэргэжлийн хүмүүсийг цуглуулан зөвлөгөөн хийж, гадаадаас өндөр үнээр авч байгаа энэ машин, краныг өөрсдөө хийж чадахгүй юу гэсэн асуудал хэлэлцэж өөрийн хүчээр хийх шийдвэр гарган хэрэгжүүлснээр амжилтад хүрсэн. Бүх зүйлийг гаднаас авна гэдэг бол яваандаа тэдний гарт орно гэсэн үг юм. Энэ мэтчилэнгээр байгаа зүйлээ өгсөөр суутал хоосон хоцорно гэсэн үг”<sup>15</sup>.

Ким Ир Сен –” Би нэлээд эрт Индонезид айлчлах үеэр ерөнхийлөгч Сукорно Жакарта хотын олон машиныг зааж Бээжингээс илүү байгаа биз дээ гэж хэлэхэд би хариуд нь тоглоомоор: Танай орон империалистуудын шинэ колоничлолын бодлогод автагдаж байна. Гадаадаас олон тооны машин авч түүнээ өөртөө ч засахгүй, сэлбэг хэрэгслийг нь авч байгаа нь аажмаар тэдний гарт орно. Энэ утгаар үзэхэд Хятад танайхаас илүү юм гэж хэлсэн. Маргааш нь Сукорно миний



хэлснийг бодож хонолоо. үнэхээр тийм юм гэж байв”<sup>16</sup> хэмээн тэмдэглэсэн.

Ким Ир Сений ярианд социалист гавшгай хөдөлмөрийн үнэр ханхалсан өөрөөр хэлбэл нэлээд амбициозный төлөвлөгөөтэй зүйл ч их ажиглагдаж байна. Энэ нь дараах зүйлд тод тусчээ. “Таван толгойн коксжих нүүрсний орд газрыг ашиглахад юуны өмнө тээврийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй юм. Хятадын нутгаар тээвэрлэх боломжгүй. Хятадын хойд нутгаар явахад ч бэрхшээлтэй. Хятадын тал манайд / Солонгост/ 600 км төмөр зам тавиад коксжих нүүрсний орд газрыг хамтран ашиглах санал тавьж байсан. Гэтэл тэнд төмөр зам тавих нөхцөл хүнд, нүүрсний чанар муу учир больсон юм. Таван толгойн коксжих нүүрсний орд газрыг ашиглахтай холбогдуулан Монголын нутагт 450 км төмөр замыг төвөггүй тавьж болох юм. Манай улс хүнд нөхцөлд төмөр зам тавьдаг нэлээд туршлагатай. Танай орон шиг байгаль газар зүйн бэрхшээл багатай газарт нэг жилийн дотор барьж болох юм гэж үзнэ”<sup>17</sup>

Ким Ир Сен нь Хятадад тийм ч сайн байгаагүйг түүний ярианаас ажиглаж болох юм. Харин оросуудад тийм ч муугүй итгэж байжээ. Тэрээр өгүүлэхдээ “Ер нь Хятад нөхөд өнгөн дээрээ сайхан загнадаг. Таван толгойн коксжих нүүрсний орд газрыг ашиглах, тээвэрлэх ажлыг Зөвлөлтийн талтай ярьж тохирох хэрэгтэй. Гэхдээ доогуур яриад бүтэхгүй. Нөхөр М.С.Горбачевтай л ярих хэрэгтэй. Нөхөр М.С.Горбачев надад амласнаар 1989 онд манай оронд айлчлах байх. Азийн оронд айлчлах бол Хятад, Японд айлчлах асуудал гарч байгаа юм. Хятад-Зөвлөлтийн харилцаа нааштай өөрчлөгдөж байгаа болохоор хэрэгжиж болох юм. Коксжих нүүрсний орд газрыг эзэмшихэд Зөвлөлтийн нутгаар дамжуулан тээвэрлэх нь илүү найдвартай. Нүүрс борлуулах зах зээл олдоно”<sup>18</sup>.

1988 оны айлчлалын үеэр Ж.Батмөнхийн Ким Ир Сенийг хүндэтгэн барьсан оройн зоогт илэн далангүй яриа өрнүүлсэн байна. Ким Ир Сен хэлэхдээ “Би 1956 онд танай оронд айлчилснаас гадна 1952 онд Москва орох замдаа нэг удаа дамжин өнгөрч байсан. Миний нэг охин уушигны өвчтэй болж ЗХУ-д эмчлүүлээд буцахдаа танай нутгаар надтай хамт явж байв. Нөхөр Ю.Цэдэнбал миний охины өвчтэйг мэдэж айргаар эмчлэхийг зөвлөн олон удаа айраг явуулж байсан. Охин маань жилийн дараа бие нь эрүүл болсон. Танай айраг эмчилгээний сайн чанартай юм билээ”<sup>19</sup>.

Ж.Батмөнх – СХН, ЗГ-ын удирдах хүмүүсээ манай оронд ирүүлж байгаарай. Нөхөр Ким Жен Ир /бодвол Ким Чен Ир/ манай оронд айлчилна гэдэгт итгэж байна гэжээ.

Ким Ир Сен хэлэхдээ “Залуу хүн ирэлгүй яахав вэ. Тэр улс орны дотоод ажлыг хариуцан их ажил хийж байна. Гадаад харилцааны асуудлыг эцэг нь хариуцаж байхад зэрэгцэж болохгүй. Ар талд ажилладаг. Бусад нөхдийг ч явуулна”<sup>20</sup>. Энэ нь хүүдээ улс орныхоо дотоод ажлыг үндсэнд нь хариуцуулаад өгчихсөн байсан хэрэг юм.

### ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Гадаад харилцааны яамны архив, Ф-3, Д-309, т.123
2. Мөн тэнд т.124
3. Мөн тэнд т.125
4. Мөн тэнд т.126
5. Мөн тэнд т.127
6. Мөн тэнд
7. Мөн тэнд т.128
8. Мөн тэнд
9. Мөн тэнд
10. Гадаад харилцааны яамны архив, Ф-3, Д-309, т.122
11. Мөн тэнд т.134
12. МАХН-ын Төв Архив Ф.4, Д.19, хн.9. х.192
13. НТА. Ф.4, д.19, хн.9, х.267
14. ГХЯ-ны архив. Ф.3, Д.64. х.39
15. Мөн тэнд х,134
16. Мөн тэнд
17. Мөн тэнд
18. Мөн тэнд
19. Мөн тэнд
20. Мөн тэнд